| | | | **14. Монгол Улсын босоо тэнхлэгийн бүсэд 2022-2024 онд хэрэгжүүлэх гео-орчин төсөл**. Төслийн хэмжээнд Гео-орчны зураг /масштаб 1:200000/, Гео-орчны эрсдэлийн үнэлгээний зураг, Баримт материалын зураг, Гео-экологийн зураг, Гео-экологийн аюулын үнэлгээний зураг, Геоморфологийн зураг, Гео-гамшгийн зураг, Гео-гамшигийн аюулын үнэлгээний зураг, Газар хөдлөл идэвхтэй хагарал, түүнтэй хам хөгжилтэй геологийн хүчин зүйлийн зураг, Газар хөдлөл идэвхтэй хагарал, түүнтэй хам хөгжилтэй геологийн хүчин зүйлийн урьдчилсан аюулын үнэлгээний төрөл зэрэглэлийн зураг, Гидрогеологийн зураг, Гидрологийн зураг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын зураг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хэтийн төлөв-үнэлгээний зургууд зохиогдон тайлбар бичиг, мэдээллийн сан бүхий үр дүнгийн тайлан зохиогдож ЭБМЗ-ийн хурлаар оруулж хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна. Тус талбайн хэмжээнд өмнөх судалгаагаар түгээмэл тархацтай ашигт малтмалын 306 орд, 40 илрэл тэмдэглэгдсэн байдаг Төслийн ажлын үр дүнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хэтийн төлөвтэй байж болох элсний 15, элс-хайрганы холимогийн 12, шаврын 5, барилгын чулууны 41, өнгөлгөөний чулуу 11, нийт урьдчилсан байдлаар 81 илрэл тогтоогдоод байна. Үүнээс уулын ажил, геофизикийн ажил болон дээжлэлийн үр дүнгээр 20 илрэлд баялаг тооцсоноос барилгын элсний 3 талбайд P зэргээр 5.6 сая м.куб, барилгын чулууны 8 талбайд P зэргээр 14.2 сая м.куб, элс хайрганы 6 талбайд P зэргээр 9.8, Өнгөлгөөний чулууны 2 талбайд P зэргээр 8.2 сая м.куб, шаврын 1 талбайд P зэргээр 3.2 сая м.куб баялаг тооцсон үр дүнгийн тайлан зохиогдож, ЭБМЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар орж хамгаалагдсан. |

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

2025 оны 12 дугаар сарын 17

Үндэсний геологийн албаны 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 1/903 дугаартай албан бичгийн 3 дугаар хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**
**/8 арга хэмжээ/**

2025 он

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| № | ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Хамтрагч | Төсөв (сая төгрөг) | Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр) | | Хэрэг жилтийн хувь |
| | | | | | | | | 2025 ОН | | |
| | | | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | |
| 3.3.1 УУЛ УУРХАЙ | | | | | | | | | | |
| 1 | | 555 | Агаарын геофизикийн 1:200000-ны масштабтай цогцолбор судалгааны ажлаар Монгол орны нутаг дэвсгэрийн хамрагдах хувийг нэмэгдүүлэх | 2025 | АҮЭБЯ | ҮГА | Улсын төсөв | 12% | **1. Соронзон-2023 төсөл** “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ болон “Иккскалибур авиашн ХХК”-ны түншлэлийн хүрээнд судалгааны шинэ арга аргачлал болох агаарын хүндийн хүчний градиометр (AGG) судалгааг болон агаарын соронзон, агаарын радиометр (Mag+Rad)-ын хэмжилтийг комплекс хэлбэрээр нийт урт 4164 т.км агаарын нислэгийн ажлыг 100% гүйцэтгэн, датаг боловсруулсны үр дүнд Хөх нүдэн, Мөргөцөг, Баянхошуу, Далайн дуулга уул эрлийн талбайг ялган, газрын нарийвчилсан 1492 т.км соронзон судалгаа, цэг хооронд 100м зайтай 9 шугамаар нийт 280 | 98% |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.3.1.2. Геологийн судалгаа, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэн, шинэ орд газруудыг нээж, газрын хэвлийн нэгдсэн геомэдээллийн санг бүрдүүлнэ; | | | | | | | | ф.цэгийн ТЕМ буюу цахилгаан соронзон хайгуулыг, цэг хооронд 100м зайтай янз бүрийн чиглэлтэй 10 шугамаар нийт 400 ф.цэгийн хүндийн хүчний орны судалгааг хийж үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хурлаар оруулж хэлэлцүүлэхээр хурлын товыг хүлээж байна.<br><br>**2. Агаарын геофизик-2024** 2. Агаарын геофизик-2024 төслийн хүрээнд Агаарын геофизикийн 1:200000-ны масштабтай цогцолбор судалгааны ажил: Агаарын геофизик-2024 төслийн хүрээнд өнөөдрийн байдлаар Агаарын геофизикийн "Tempest" цахилгаан соронзон болон нэмэлтээр нэгэн зэрэг хэмжих багажууд болох Scintrex CS-3 соронзон орны, RS радиометрийн, iCORUS хүндийн хүчний төхөөрөмжүүдээр талбайн геофизикийн цогц системээр хэмжилт, боловсруулалтын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд энэ онд гүйцэтгэх төсөв, төлөвлөгөөг ЭБМЗ-ийн хурлаар оруулж батлуулсан. Өнөөдрийн байдлаар төлөвлөгөөний дагуу геофизикийн хэмжилтийн нислэгийн ажил бүрэн хийгдэж, газрын шалгалт, дээжлэлтийн ажил, үр дүнгийн тайлан боловсруулалтын ажил хийгдэж байна. Энэ төсөл нь гэрээний хугацаанд буюу 2025 оны 12 дугаар сарын 30-нд багтааж ЭБМЗ-ийн хурлаар орж хамгаалагдсанаар Монгол орны нутаг дэвсгэрийг 12.94 %-ийг хамруулна.<br>**3. Агаарын геофизик-2025** төсөл: Монгол орны Хангайн бүсийн хэмжээнд 135,766.8 кв.км талбайд Агаарын соронзон, гамма цацрагийн спектрометр (нийлбэр цацраг, уран, тори, кали) болон дагалдах судалгааг хийх Агаарын геофизик-2025 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан. Гүйцэтгэгчээр Гео сан ХХК шалгарч гэрээ байгуулан судалгааны ажлыг эхлүүлж 2025 онд 5 сувгийн хэмжилтийн нислэгийг 42700 тууш/км буюу нийт судалгааны талбайн 50%-ийг харуулан хэмжилтийн ажлыг гүйцэтгэсэн. | |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | 556 | 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар Монгол орны нутаг дэвсгэрийг хамруулах % | 2025 | АҮЭБЯ | ҮГА | Улсын төсөв | 48% | **1. "Ямаат уул-50"** төслийн үр дүнгээр 12 давхраат хурдас, гүний 4 бүрдэл ялгаж, ашигт малтмалаар Хэтийн төлөв сайтай "А" зэрэглэлийн 4 талбай. Үүнд: А1 талбай: Элстэйн алтны шороон хуримтлал тогтоогдсон /баялгийн үнэлгээ P2 зэрэглэлээр алт 14.73кг/, А2 талбай: Цант-Уулын ордод "А" зэрэглэлээр нүүрс 6.612 сая.тн, "В" зэрэглэлээр 5.250 сая.тн, "С" зэрэглэлээр 16.1 сая, А3 талбай: Бүдүүний хярын ордод нүүрсийг (В+С) зэрэглэлээр 10.2 сая.тн, А4 талбай: Цагаан толгойн нүүрсний орд, Ботго толгойн нүүрсний илрэл, "Б" зэрэглэлийн хэтийн төлөв сайтай хангалтгүй судлагдсан 4 талбайг ялгасан. Үүнд:<br>-Б1 талбай: Цахир толгойн эпитермаль гаралтай алтны 1 илрэл, Au-0.2-0.35гр/тн, P2 зэргээр тооцоход алт 96,9кг,<br>-Б2 талбай: Хайрхан уул /P2=112 500тн зэс/, Ямаат уулын зэсийн илрэл, алтны 3, зэсийн 6-н эрдсэжсэн цэг, зэсийн 2 цэгэн гажил, шлихээр алтны-2 тэмдэгт цэг, пиритийн сарнилын хүрээ, геохимиэр зэсийн-4, марганец-1, титан-1 сарнилын хүрээ, никель, хромын цэгэн гажлууд тогтоогдсон.<br>-Б3 талбай: Бага Өвгөн уулын зэсийн эрлийн талбайд ялгагдсан Илрэл 1-д P2 зэрэглэлээр Cu 225 000тн, илрэл 2-д P2 зэрэглэлээр Cu 1500тн, илрэл 3-д P2 зэрэглэлээр Cu 91 125тн буюу нийт зэс 317 625тн,<br>-Б4 талбай: Бага Өвгөн уулын хүдрийн талбай /6.7кв.км/ ялгасан. Шлихээр зэс, хар тугалганы тэмдэгт цэгүүд, геохимиэр зэс, хар тугалганы гажигт цэгүүд тогтоогдсон. Цаашид зэсийн хүдэржилт илрүүлэгдэх хэтийн төлөвтэй гэж үзэн дараагийн ээлжид нарийвчилсан эрлийн ажил явуулах боломжтой, Хэтийн төлөв тодорхойгүй, хангалтгүй судлагдсан "В" зэрэглэлийн 14 талбайг ялгасан үр дүн бүхий тайланг ЭБМЗ-ийн УТХ-2025/02 хурлаар оруулж хэлэлцүүлэн үр дүнг хүлээн авсан.<br>**2. "Индэртийн нуруу-50"** төслийн ашигт малтмалын ажлаар тус талбайн хэмжээнд алт-хар тугалга-зэсийн 1 илрэл, зэсийн 2 илрэл, 33 эрдэсжсэн | 98% |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | цэг, 13 гажилт цэг, никелийн 2 илрэл, 7 гажилт цэг, хромын 1 илрэл 4 гажилт цэг, төмрийн 3 эрдэсжсэн цэг, алтны үндсэн илрэл 8, шороон илрэл 3, эрдэсжсэн цэг 13, гажилт цэг 17, вольфрамын 5 илрэл, 3 гажилт цэг, мөнгөний 2 гажилт цэг, цайрын 10 гажилт цэг, барит-стронциатын 1 илрэл, 5 эрдэсжсэн цэг, барийн 3 гажилт цэг, стронцийн 17 гажилт цэг, хар тугалганы 1 илрэл, 6 эрдэсжсэн цэг, никелийн 2 илрэл, 7 гажилт цэг, бериллийн 1 эрдэсжсэн цэг, 1 гажилт цэг, литийн 9, иттрийн 1,цайрын 10, мангааны 6 гажилт цэгүүдийг шинээр илрүүлэн урьдчилсан үнэлгээ өгсөн. Мөн түүнчлэн, зэс, цайр, хар тугалга, молибден, цагаан тугалга, мөнгө, бари, кобальт зэрэг элементүүдийн 150 урсгал сарнилын хүрээ, 125 гажилт цэг, шеелит, барит, хар тугалга, мангаан, корунд, флюорит, ксенотим, алт, торит-оранжит зэрэг эрдсийн 104 шлихийн сарнилын хүрээ, 275 урсац болон гажилт цэгүүдийг илрүүлэн тэмдэглэв. Металл бус ашигт малтмалаас барилгын өнгөлгөөний чулуу, барилгын шавар, барилгын элс, гоёл чимэглэлийн чулуу, гипс, магнезитын илрэлүүд тогтоосон үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар оруулж, хэлэлцүүлэн үр дүнг хүлээн авсан.<br>**3. “Хар хайрхан-50”** төслийн ажлаар давхраат хурдас 11, интрузив 6 бүрдэл ялгаж, ашигт малтмалын ажлаар илрэл 18ш, бүлэг эрдэсжсэн цэг-5, эрдэсжсэн цэг-90, гажил цэг-166ш, шлихийн сарнилын хүрээ-69, хоёрдогч геохимийн сарнилын хүрээ-96ш шинээр нэмж илрүүлсэн. Төслийн талбайд 24 талбай ялгаж, эрлийн ажил хийснээс 19, илрэлийн хэмжээнд баялгийн үнэлгээг тооцож, дараах төрлийн ашигт малтмалын баялгуудыг тогтоожээ. Үүнд: Зэс /Cu/-1,728,904тн, Молибден /Mo/-36,162тн, Хар тугалга /Pb/-141,033тн, Алт /Au/-4,467кг, Мөнгө /Ag/-1,139кг, Гипс-1,557,659тн, Хүрэн нүүрс-127,981,048тн, Өнгөлгөөний чулуу-494,035тн баялаг илрүүлсэн үр дүн бүхий тайланг ЭБМЗ-ийн 2025 оны | |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 10 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар оруулж, хэлэлцүүлэн үр дүнг хүлээн авсан.<br>**4. “Буйлст хүрэн уул-50"** төслийн ажлаар давхраат хурдас 12, интрузив 3 бүрдэл ялгаж, ашигт малтмалын ажлаар 13 илрэл, 47 эрдэсжсэн цэгийг шинээр илрүүлэн Барилгын материал ба өнгөлгөөний чулууны 7, өнгөт ба гоёл чимэглэлийн чулууны 3, оптикийн түүхий эдийн 1, алтны 2 илрэл болон холимог металын 3, цацраг идэвхт элементийн 1, үнэт металын 9, өнгөт металын 19 эрдэсжсэн цэг шинээр илрүүлсэн, үр дүн бүхий тайланг ЭБМЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар оруулж, хэлэлцүүлэн үр дүнг хүлээн авсан. Мөн Цагаан овоо-50, Их бэрх уул-50, Их элээт уул-50, Их өлзийт-50 төслүүдэд шинжээч нарын дүгнэлт гарч, тойрох хуудсаар холбогдох мэргэжилтнүүдээр хянагдаж ЭБМЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын УТХ-2025-05 дугаар хуралдаанаар орж хэлэлцүүлэгдсэнээр 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар Монгол орны нутаг дэвсгэрийн 79,34 хувийг хамруулсан.<br>**5. Үр дүнгийн тайлан боловсруулалтын ажил гүйцэтгэж байгаа:**<br>- **Үүрэг нуур-50 төсөл:** 12 давхраат хурдас, гүний 6 бүрдэл ялгаж, ашигт малтмалаар Мэргэн булаг /Cu, As/, Хэрээтийн даваа /Cu/, Зүүн үүрэг /Fe (Mn,Ti)/, Цагдуул уул/Fe/, Урт булаг /Fe/, Дарьт уул /Pb,Zn,Ag/ илрэлүүдийг тус тус тогтоож баялаг үнэлэх ажил хийгдгсэн.<br>-**Мөст уул-50 төсөл:** 10 давхраат хурдас, гүний 6 бүрдэл ялгаж, ашигт малтмалаар, Баясгалан уулын Fe-Ti-ний илрэл, Замын Fe-Ti-ний илрэл, Дархан уулын Fe-Ti-ний илрэл, Овоотын арын Fe-Ti-ний илрэл, Дэлгэрэнгүй уулын Fe-Mn-ний илрэлүүдийг тус тус тогтоож баялаг үнэлээ хийгдсэн.<br>- **Баянзүрх уул-50 төсөл:** 6 давхраат хурдас, гүний 6 бүрдэл ялгаж, ашигт малтмалаар Булганы зэсийн илрэл, Дамбацэрэнгийн зэсийн илрэл, Зоондавааны зэсийн илрэл, Шаварт улааны вольфрамын | |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | илрэлүүдийг тус тус тогтоож баялаг үнэлэх ажил хийгдсэн.<br>**-Ханхар уул-50 төсөл:** 11 давхраат хурдас, гүний 5 бүрдэл ялгаж, ашигт малтмалаар Мойльтын зэсийн илрэл, Хавиргын зэсийн илрэл, Ханхар уулын зэсийн илрэлүүдийг тус тус тогтоож баялаг үнэлэх ажил хийгдсэн.<br>**-Ямбат уул-50 төсөл:** 11 давхраат хурдас, гүний 6 бүрдэл ялгаж, ашигт малтмалаар Шовон уулын зэсийн илрэл, Хайрханы зэсийн илрэл, Өмнөдийн зэсийн илрэл, Оргихын хөндийн зэсийн илрэл, Нүүрст хөтлийн чулуун нүүрсний илрэл, Тахилт уулын хайлуур жоншны илрэлүүдийг тус тус тогтоож баялаг үнэлэх ажил хийгдсэн.<br>**-Овоот шар-50 төсөл:** 6 давхраат хурдас, гүний 2 бүрдэл ялгаж, ашигт малтмалаар Улаан толгойн зэс-алтны илрэл, Есөн нуурын зэсийн илрэл, Шар булгийн зэсийн илрэл, Шар нохойтын алт-зэсийн илрэлийн тус тус тогтоон үр дүнгээр тайлан зохиох ажлууд хийгдсэн үр дүнтэйгээр эцсийн тайлангийн боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна.<br>**6. ЭБМЗ-ийн хурлаар орох бэлтгэл ажил явагдаж буй төслүүд:** Монгол орны нутаг дэвсгэрийн 1,6 хувийг хамарсан Ширээт уул-50, Борзонгийн говь-50, Улаангом-50, Бөөн хөх уул-50, Загал уул-50, төслүүдийн үр дүнгийн тайлан зохиогдож, Монголын стратиграфийн комисс болон ЭБМЗ-өөс томилогдсон шинжээчээр хянагдаж байна.<br>**7. 2025 онд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн төслүүдийг шинээр эхлүүлэхээр** тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж, 8 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулж судалгааны ажлыг эхлүүлсэн. Үүнд: Хатан хайрхан-50 төслийн гүйцэтгэгчээр Алтайн хар азарга групп ХХК, Боршоо-50 төслийн гүйцэтгэгчээр Эрээн чулуу ХХК, Цээл-50 төслийн гүйцэтгэгчээр Гео эрин ХХК, Номингийн говь-50 төслийн гүйцэтгэгчээр Ихцог өндөр ХХК, | |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Таянгийн хөх нуруу-50 төслийн гүйцэтгэгчээр Литос майнинг ХХК, Сайн уул-50 төслийн гүйцэтгэгчээр Сутур зона ХХК, Тэх уул-50 төслийн гүйцэтгэгчээр БАСИС ХХК тус тус шалгарч гэрээг байгуулан, хээрийн судалгааны ажлыг эхлүүлж, нийт 12776 кв.км талбайн зургын тайлалт, боловсруулалт, 4136 кв.км геологийн зураглалын ажлыг гүйцэтгэж, талбайн шлихийн сорьцлолт 3872 ш, урсгал геохимийн 3872, анхдагч геохимийн 859 дээж сорь авч шинжилгээнд хамруулсан. | |
| | | | Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100% хамруулна. | 2025 | АҮЭБЯ | ҮГА | 2025 оны байдлаар гүйцэтгэл: | L, M /N/ хавтгай буюу нутаг дэвсгэрийн 100%ийг бүрхэх, үр дүнг хүлээн авна. | **1. Монгол орны L хавтгайн** хэмжээнд хийгдсэн улсын геологийн 1:200000-ны масштабтай иж бүрдэл зургийг нэгтгэх ажлын үр дүнд L эгнээний нийт 160, нэгтгэснээр 152 хавтгайн УГЗ-200 иж бүрдлийн геологи, ашигт малтмал, дөрөвдөгчийн геологи, экологи-геологи, баримт материалын шинэчилсэн зургуудыг зохиож, тоон мэдээлэлд оруулж, мэдээллийн санг нь шинэчилж УГЗ-200 иж бүрдлийн хоёрдугаар хэвлэлийг бэлтгэсэн. Ашигт малтмалын зурагт минерагений бүс 42, хүдрийн болон хэтийн төлөв бүхий дүүрэг 169, хүдрийн зангилаа болон хүдрийн хэтийн төлөв бүхий зангилаа 241, сав газар, хэтийн төлөв бүхий сав, хүдрийн болон хэтийн төлөв бүхий талбай 132, нүүрст талбай, 167 бүлэг (илрэл, эрдэсжсэн цэг, шлих, геохимийн хүрээ)-ийн жагсаалтыг өгч, ашигт малтмалын зураг, хүснэгт бүхий тайлан зохиогдсон.<br>Төслийн нэгтгэлийн үр дүнд L хавтгайн хэмжээнд ашигт малтмалын хувьд өмнөх судалгааны материалуудад бүртгэгдсэн металл ашигт малтмалын 1780 орд, илрэл, шороон ордын 306 илрэл, үйлдвэрлэлийн эрдсийн 947 орд, илрэл, шатдаг ашигт малтмалын 316 орд, илрэл, эрдэс давсны 80 орд, илрэл, барилгын материалын 790 орд, илрэл, рашаан усны 119 орд, илрэлийг тоон мэдээллийн санд шинэчлэн бүртгээд байна. Улсын геологийн зургийн редакц болон ЭБМЗ-өөс томилогдсон шинжээчээр хянагдаж байна. | |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | **2.УГЗ-200-М лист нэгтгэл** төслийн хэмжээнд Улсын геологийн зураг зохиох төслүүдийн ажлыг нэгтгэх, геологийн судалгааны хувьд шийдвэрлэгдээгүй асуудлыг шинэчлэх ажлын хүрээнд үндсэн иж бүрдэл 1:200000 масштабын болон, дагалдах 1:500000-ны масштабын тойм зургууд 125 буюу томсгосон байдлаар 97 хавтгай тус бүрд зохиогдоод байна. Төслийн талбайд өмнөх судалгааны ажлуудаар хийгдсэн ашигт малтмалын зураг, бичвэрийг нэгтгэсэн тайлан зохиогдсон. Үүнд металл ашигт малтмалын 644 орд, илрэл, алтны шороон орд, илрэлийн 47, үйлдвэрлэлийн эрдсийн 187 орд, илрэл, шатах ашигт малтмалын 45 орд, илрэл, эрдэс давсны 19 орд, илрэл, Барилгын материалын 190 орд, илрэл тус тус тоон мэдээллийн санд шинэчлэгдэн бүртгээд байна. Төслийн үр дүнгийн тайлан Улсын геологийн зургийн редакц болон ЭБМЗ-өөс томилогдсон шинжээчийн дүгнэлт гарч хуралдаанд оруулах бэлтгэл ажил бүрэн хангагдаж, хурлын товыг хүлээж байна. 2 төсөл ЭБМЗ-ийн хурлаар орж хамгаалагдсанаар Монгол орны K, L, M листийн хэмжээнд 1:200000 масштабын иж бүрдэл зураг нэгтгэгдэнэ. | |
| 3 | | 557 | 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх | 2025 | АҮЭБЯ | ҮГА | Улсын төсөв | 0.05 | Аж үйлдвэр эрдэс баялгийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөг баталж Хархорин-25 төслийг эхлүүлэхээр геологийн даалгаврыг баталж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг эхэлсэн боловч, Монгол улсын 2025 оны төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан Геологийн судалгааны ажлын тодотгосон төсөв, төлөвлөгөө батлах тухай Аж үйлдвэр эрдэс баялгийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/189 дүгээр тушаал энэхүү төсөл 2025 онд эхлээгүй бөгөөд 2026 оны төсөв, төлөвлөгөөнд тусган ажилласан. | /Хб/ |
| 4 | | 558 | Геохимийн 1:200000-ны | 2025 | АҮЭБЯ | ҮГА | Улсын төсөв | 1 | 1. **Геохими-2023 төсөл:** Нийт 954.68 км2 талбайн хэмжээнд хоёрдогч геохимийн сорьцыг 500x250м | 95% |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
|  |  |  | масштабын зураг зохиох сэдэвчилсэн судалгааны ажлыг шинээр эхлүүлсэн байна **/1 төсөл/** |  |  |  |  |  | торлолоор, зүүн-баруун чиглэлийн шугамаар сорьцлолт хийж 7703ш дээж авч үр дүнг боловсруулан Далай дуулга уул, Мөргөцөг, Баянхошуу, Таван тахил, Хөх нүдэн зэрэг 5 эрлийн талбай ялган 200x100м тороор анхдагч болон хоёрдогч геохимийн нийт 8996ш дээжийг авч эрэл-шалгалтын маршрутыг нийт 320т/км гүйцэтгэж, маршрутын явцад цэглэн-125ш, силикат-30ш, хувирал-220ш, шлиф-50ш, аншлиф-30ш дээжлэлт зэрэг уулын болон хээрийн үйлдвэрлэлийн ажлууд, лабораторийн ажлын боловсруулалтын үр дүнгээр тайлан зохиогдож, ЭБМЗ-ийн томилогдсон шинжээчийн дүгнэлт гарч хурлаар орж хэлэлцүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдсан.<br>**3. Геохими-2025 төсөл**: 2025 онд шинээр эхлүүлсэн Баруун монголд 194,505.57 кв.км талбайн хамарсан 1:200000-ын масштабын геохимийн зураглал хийх, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан. Гүйцэтгэгчээр Дипирамид ХХК шалгарч гэрээ байгуулан 1 төслийн ажлийг шинээр эхлүүлж, хээрийн үйлдвэрлэлийн ажлыг эхлүүлж, судалгааны ажлаар сорьцлолтын 6 баг Ховд аймгийн Чандмань, Зэрэг, Манхан, Мөнххайрхан, Жаргалант, Мөст, Дуут, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумдын нутагт 1:200 000-ны масштабын L- хавтгайн хэмжээнд 79,000 кв.км талбайд 4472ш сорьцлолтын ажлыг гүйцэтгэсэн. |  |
| 5 |  | 559 | Геологийн тектоник, инженер-геологи, структур-гидрогеологийн зургууд зохиох төслүүдийг /шинээр эхлүүлэх 3 | 2025 | АҮЭБЯ | ҮГА | Улсын төсөв | 3 | 1. Аж үйлдвэр эрдэс баялгийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөг баталж Тектоник-2025, Инженер геологи-2025 төслүүдийг шинээр эхлүүлэхээр геологийн даалгаврыг баталж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг эхэлсэн боловч, Монгол улсын 2025 оны төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан Геологийн судалгааны ажлын тодотгосон төсөв, төлөвлөгөө батлах тухай Аж үйлдвэр эрдэс баялгийн | 85% |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төсөл/ болон бусад үргэлжилж байгаа сэдэвчилсэн судалгааны ажлуудыг гүйцэтгэх /үргэлжилэн хэрэгжиж буй 3 төсөл/ | | | | | | сайдын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/189 дүгээр тушаалаар энэхүү 2 төсөл хэрэгжиж эхлээгүй болно.<br>2. Монгол Улсын Их хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 85 дугаар тогтоолоор Алт-3 хөтөлбөр батлагдсанаар Аж үйлдвэр эрдэс баялгийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/189 дүгээр тушаал гарч Хойд Хэнтийн минерагений бүсийн Заамарын хүдрийн зангилааны геологи, стратиграфи, седиментологийн судалгаа, Хойд бүсийн геодинамик-металлогений судалгаа 2 төслийг шинээр эхлүүлэхээр төсөв, төлөвлөгөө баталж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, 2 төслийн шинээр эхлүүлсэн.<br><br>**1. Монгол Улсын босоо тэнхлэгийн бүсэд 2022-2024 онд хэрэгжүүлэх гео-орчин төсөл**. Төслийн хэмжээнд Гео-орчны зураг /масштаб 1:200000/, Гео-орчны эрсдэлийн үнэлгээний зураг, Баримт материалын зураг, Гео-экологийн зураг, Гео-экологийн аюулын үнэлгээний зураг, Геоморфологийн зураг, Гео-гамшгийн зураг, Гео-гамшигийн аюулын үнэлгээний зураг, Газар хөдлөл идэвхтэй хагарал, түүнтэй хам хөгжилтэй геологийн хүчин зүйлийн зураг, Газар хөдлөл идэвхтэй хагарал, түүнтэй хам хөгжилтэй геологийн хүчин зүйлийн урьдчилсан аюулын үнэлгээний төрөл зэрэглэлийн зураг, Гидрогеологийн зураг, Гидрологийн зураг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын зураг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хэтийн төлөв-үнэлгээний зургууд зохиогдон тайлбар бичиг, мэдээллийн сан бүхий үр дүнгийн тайлан зохиогдож ЭБМЗ-ийн хурлаар оруулж хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна. Тус талбайн хэмжээнд өмнөх судалгаагаар түгээмэл тархацтай ашигт малтмалын 306 орд, 40 илрэл тэмдэглэгдсэн байдаг Төслийн ажлын үр дүнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хэтийн төлөвтэй байж болох элсний 15, элс-хайрганы холимогийн 12, шаврын 5, барилгын чулууны 41, | |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | өнгөлгөөний чулуу 11, нийт урьдчилсан байдлаар 81 илрэл тогтоогдоод байна. Үүнээс уулын ажил, геофизикийн ажил болон дээжлэлтийн үр дүнгээр 20 илрэлд баялаг тооцсоноос барилгын элсний 3 талбайд P зэргээр 5.6 сая м.куб, барилгын чулууны 8 талбайд P зэргээр 14.2 сая м.куб, элс хайрганы 6 талбайд P зэргээр 9.8, Өнгөлгөөний чулууны 2 талбайд P зэргээр 8.2 сая м.куб, шаврын 1 талбайд P зэргээр 3.2 сая м.куб баялаг тооцсон үр дүнгийн тайлан зохиогдож, ЭБМЗ-ийн хурлаар 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн УТХ-2025-03 дугаар хуралдаанаар орж хэлэлцүүлэн хамгаалагдсан.<br><br>**2. Мезо-Кайназой-2021 төсөл.** Монгол орны хэмжээнд тархсан мезо-кайнозойн хурдасны түвшинд шийдэгдээгүй олон асуудал (стратиграфийн нэгжийн нэрсийн давхардал, үндэслэл, үнэмлэхүй нас, зүсэлт, хил заагийн маргаан)-ыг шийдвэрлэж, баталгаажуулж түүндээ тулгуурлан геологийн 41 лист, ашигт малтмалын 41 лист, тектоникийн 41 листийн зургуудыг тус тус анх удаа 1:500000-ны масштабаар зохиогдож, дагалдан 74 төрлөөр мэдээллийн сан бүрдүүлсэн, үнэмлэхүй насны 66 шинэ өгөгдөл, дээжийн тодорхойлолт, тунамал ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ бүхий тайлбар бичиг зохиогдсон. Үр дүнгийн тайлан Улсын геологийн зургийн редакц, ЭБМЗ-өөс томилогдсон шинжээч нараар хянагдаж хурлаар оруулж хэлэлцүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.<br><br>**3. "Баруун Монголын зарим бүсийн тектоник ба шатах ашигт малтмалын хэтийн төлөв" сэдэвчилсэн судалгааны "БМШАМ-2022" төсөл.** 1:200 000-ны масштабтай номенклатурын 18 хавтгайн тектоникийн зураг, нэгдсэн таних тэмдэг, болон шатах ашигт малтмалын зураг /7 хавтгай/, 1:500000-ны масштабтай Баруун Монголын тектоникийн, баримт материалын болон шатах ашигт малтмалын хэтийн төлөвийн зураг, сонгосон 3 | |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | талбайн 1:25000-ны масштабтай геологи-структурын зураг, тайлбар бичиг бүхий үр дүнгийн тайлан зохиогдож ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна. Нийт 14 байршил дах 10 формацийн хурдаснаас 33 дээж авч рко-эвал пиролиз хийхэд газрын тос үүсгэгч чулуулаг тогтоогдоогүй тул газрын тосны хэтийн төлөвийг үнэлэх боломжгүй байв. Судалгааны талбайн нүүрсний баялгийг Хархираан сав газарт (дээд карбон) 0-600м гүнд P2 зэргээр 3,060.5 сая тн, Монгол- Алтайн сав газарт (доод-дунд юра) 0-300м гүнд P3 зэргээр 387.8 сая тн гэж тооцсон. Эдгээрийг нүүрсийг шингэрүүлэхэд тохиромжтой. НДМ-ны баялгийг "PRMS" аргачлалын дагуу "Хийн анхдагч нийт хуримтлал"-ыг үнэлсэн. Палеозойн тэнгисийн хурдаст, гүн усны шаварлаг чулуулгийн зузаалгийг тогтоовол уламжлалт бус газрын тосны хуримтлал шинээр тогтоогдсон үр дүн бүхий тайланг 2025 оны 11 дүгээр сарын 05-ний өдөр ЭБМЗ-ийн хурлаар орж хэлэлцүүлсэн, хурлаас тайланд засвар оруулах шийдвэр гаргасан.<br><br>**4. "Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:1000000-ын масштабтай структур гидрогеологийн зураг зохиох сэдэвчилсэн судалгааны ажил"** төслийг 2025 онд шинээр эхлүүлэхээр геологийн даалгаврыг боловсруулан батлуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгуулах ажлыг зохион байгуулж ажилласнаар "Мон гидрогео күйст консалтинг" ХХК гүйцэтгэгчээр шалгарч 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, хээрийн судалгааны ажлыг эхлүүлж, Өмнөговь, Баян-Өлгий, Дорноговь, Говь-Алтай, Өвөрхангай, Хэнтий, Дорнод аймгийн нутгуудад 23 цэгт шавхалт туршилтын ажил гүйцэтгэж гидрогеологийн параметр тооцох анхдагч мэдээллийг авсан мөн 48 цэгт геофизикийн судалгааг гүйцэтгэсэн. | |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | | 560 | Гадаад орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан үр ашигтай геологийн шинжлэх ухааны судалгааны 1 төслийг шинээр эхлүүлсэн байна. | 2025 | АҮЭБЯ | ҮГА | Улсын төсөв | 1 | “Монгол улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан Хойт, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени төслийн VI үе шат сэдэвчилсэн судалгааны ажил”-ын геологийн даалгаврыг боловсруулж батлуулан, гүйцэтгэгчийг сонгон шалгуулах ажлыг зохион байгуулж ажилласнаар “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ гүйцэтгэгчээр шалгарч 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан судалгааны ажлыг **1 төслийг шинээр эхлүүлсэн**, хээрийн үйлдвэрлэлийн ажлаар Геологийн судалгаа – шинжилгээний төв ТӨҮГ-ын геологичид, судлаачид болон БНХАУ-ын ШУА -ын геологийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын хамтарсан баг Төв Монгол, Баруун Монголын дүүрэгт глобал геохими, Их Алтайн хамтарсан хээрийн судалгааны ажлыг амжилттай эхлүүлэн Нуур, Алтайн бүсүүдэд глобал геохимийн 500 гаруй, силикат геохимийн 40, үнэмлэхүй насны 20 гаруй дээжлэлт, геологи судалгааны ажлыг гүйцэтгэж байна. | 98% |
| 7 | | 561 | Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн геологийн суурь судалгаа болон эрлийн ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгч баялгийн хэмжээг тооцох 1 төслийг | 2025 | АҮЭБЯ | ҮГА | Улсын төсөв | 1 | **1. Өндөр технологийн түүхий эд-2” төсөл.** Өндөр технологийн түүхий эд II төсөл нь /ГХЭ, лити, берилли, никель, кобальт, бал чулуу/-ийн эрлийн ажил болон тэдгээрийн хэтийн төлөвийг тодорхойлон үнэлгээ өгч, тайлбар бичиг, мэдээллийн сан бүхий үр дүнгийн тайлан зохиогдсон. Өмнөх судалгааны ажлаар бүртгэгдсэн нийт 1156 илрэл, эрдэсжсэн цэгүүдээс 780 объектыг ялган авч, хээрийн судалгаанд хамруулсан. Эрлийн нарийвчилсан 8 талбайн хэмжээнд хэтийн төлөвийг тодорхойлсон: ГХЭ- 10 илрэл, 1 эрдэсжцэн цэг, (Li-Be)- 10 илрэл, Ni (Co)- 2 илрэл, Ni (Cr)- 2 илрэл, Ni (Sb)- 2 илрэл, Ni-1 илрэл, бал чулууны 3 илрэл. Үүнээс баялаг тооцсон нь: ГХЭ-ийн нэг илрэлд P зэргээр 6,750 тн TR; гурван илрэлд C зэргээр 46.26 тн болон арван илрэлд P зэргээр 4517.89 тн $TR_2O_3$; хоёр илрэлд ГХЭ-ийн нийлмэл ислийн металл C зэргээр 36.14 тн болон P зэргээр 278.48 тн; Ni-Co-ийн нэг илрэлд P зэргээр 52,684.8 тн Ni, 940.8 тн Co, 10,348.8 тн Cr, 3,246,566.4 | 99% |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ЭБМЗ-ийн хурлаар оруулж хамгаалагдсан байна. | | | | | | тн Mg, бал чулууны хоёр илрэлд P зэргээр 210,012.3 тн баялаг тооцсон үр дүнгийн тайлан зохигдож, ЭБМЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ний өдрийн хурлаар орж хамгаалагдсан. | |
| 8 | | 562 | Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын эрэл, үнэлгээний ажил хийх, үнэлгээ өгч нөөц, баялгийн хэмжээг тооцох 1 /төсөл/ | 2025 | АҮЭБЯ | ҮГА | Улсын төсөв | 1 | **1**. "Мета-алт-500" төсөл Монгол орны өмнөд бүсийн алтны хүдэржилт, хэтийн төлөвийн судалгаа болон монгол орны алтны металлогений 1:500000-ны масштабтай зургийг 2022-2025 онд зохиох сэдэвчилсэн судалгааны "Мета-алт-500" төсөл. Төслийн талбайн суурь болон эрлийн талбайн зургуудыг боловсруулж байгаа бөгөөд эрлийн 19 талбайд хэтийн төлөвийн үнэлгээ өгч, илрэлийн түвшинд P3, хүдрийн талбай дүүргийн хувьд Ципфс, US 3 талт оролцооны арга, Монте Карло аргачлалуудаар баялаг тооцох ажлууд хийгдэж байна.<br><br>**2**. "Эрэл үнэлгээ-4-2022" төсөл Монгол орны металлогений дүүрэгчлэлээр Хөх морьт-Хасагтын металлогений бүс, Нуурын металлогений бүс, Дарив-Есөнбулагийн металлогений бүс гэсэн 3 томоохон бүсүүдийг дамнан байрлана. Талбайн ихэнх хэсгийг Хөх морьт-Хасагтын металлогений бүс эзлэх ба энэхүү бүсийн хэмжээнд Хасагт хайрхны потенциал дүүрэг, Өндөрбогд-Баянбогдын потенциал дүүрэг гэсэн 2 потенциал дүүрэг, 2 хүдрийн зангилаа, 10 хүдрийн талбай зэргийг ялган ангилж, эдгээр хүдрийн потенциал дүүрэг, хүдрийн зангилаа, хүдрийн талбайнуудын хэмжээнд алтны 9 илрэл, алтны эрдэсжсэн цэг-16, алт-цайрын эрдэсжсэн цэг-2, алт-хар тугалганы эрдэсжсэн цэг-2, алт-мөнгөний эрдэсжсэн цэг-1, алт-зэсийн эрдэсжсэн цэг-1, барийн эрдэсжсэн цэг-1, висмутийн эрдэсжсэн цэг-1, зэсийн эрдэсжсэн цэг-1, зэс-алтны эрдэсжсэн цэг-2, зэс-хар тугалганы эрдэсжсэн цэг-6, зэс-цайрын эрдэсжсэн цэг-3, төмрийн эрдэсжсэн цэг-2, молибдены | 91% |

| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | эрдэсжсэн цэг-6, хар тугалганы эрдэсжсэн цэг-3, хар тугалга-мөнгөний эрдэсжсэн цэг-1, цайрын эрдэсжсэн цэг-2, цагаан тугалганы эрдэсжсэн цэг-2, цайрын эрдэсжсэн цэг-2, цайр-хар тугалганы эрдэсжсэн цэг-3, цирконы эрдэсжсэн цэг-1 нүүрсний илрэл-3 зэрэг нийт 102 илрэл, эрдэсжсэн цэг байгааг тогтоож, тус бүрийн минерагений дараалал, металлогений төрөлжилтийг гаргажээ. Түүнчлэн шороон орд байх магадлалтай бүтцийг тооцоолохоор морфоструктурын зураг, хөгжлийн структурын зураг бүхий үр дүнгийн тайлан ЭБМЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн орж хамгаалагдсан.<br><br>**3.** Аж Үйлдвэр, Эрдэс Баялгийн Сайдын тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу Монгол орны хойд хилийн бүсэд 2025-2026 онд гүйцэтгэх хойд бүсийн геодинамик-металлогений судалгааны ажил, Хойд хэнтийн минерагений бүсэд 2025-2026 онд гүйцэтгэх Эртний даргдмал болон давхацмал хотгорын хурдас, хуримтлалын судалгааны ажил 2 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, судалгааны ажлуудыг эхлүүлсэн. | |
| Дундаж үнэлгээ: | | | | | | | | | | 94,85% |

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

2025 оны 12 дугаар сарын 17

Үндэсний геологийн албаны 2025 оны ..12.. дугаар сарын ..18.....-ны өдрийн ..1/923.. дугаартай албан бичгийн 4 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛООР БАТЛАГДСАН “УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НД ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2025 он

| № | Бодлогын үндэслэл | Төсөл, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж | Үр дүнгийн үзүүлэлт | | 2025 онд шаардлагатай хөрөнгө | | Үндсэн хариуцагч /АҮЭБЯ/ | Хамтран хариуцагч /ҮГА/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 он/ | Санхүүжилтийн хэмжээ /сая.төг/ | Санхүүжилтийн эх үүсвэр | | Тайлан |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО: ЭДИЙН ЗАСАГ БҮЛГИЙН ХҮРЭЭНД. | | | | | | | | | |
| ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ. | | | | | | | | | |
| 1 | МУХТЖҮЧ-6.3.4, ЗГҮАХ-3.3.1.2 | 1.4.1.1 Агаарын геофизикийн судалгааны ажлыг гүйцэтгэх | Талбайн хамрагдалт | 66 | 50% | 21 тэрбум | Улсын төсөв | | **1. Соронзон-2023 төсөл** “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ болон “Икскалибур авиашн ХХК”-ны түншлэлийн хүрээнд судалгааны шинэ арга аргачлал болох агаарын хүндийн хүчний градиометр (AGG) судалгааг болон агаарын соронзон, агаарын радиометр (Mag+Rad)-ын хэмжилтийг комплекс хэлбэрээр нийт урт 4164 т.км агаарын нислэгийн ажлыг 100% гүйцэтгэн, датаг боловсруулсны үр дүнд Хөх нүдэн, Мөргөцөг, Баянхошуу, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Далайн дуулга уул эрлийн талбайг ялган, газрын нарийвчилсан 1492 т.км соронзон судалгаа, цэг хооронд 100м зайтай 9 шугамаар нийт 280 ф.цэгийн ТЕМ буюу цахилгаан соронзон хайгуулыг, цэг хооронд 100м зайтай янз бүрийн чиглэлтэй 10 шугамаар нийт 400 ф.цэгийн хүндийн хүчний орны судалгааг хийж үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хурлаар оруулж хэлэлцүүлнэ.<br><br>**2. Агаарын геофизик-2024** төслийн хүрээнд Агаарын геофизикийн 1:200000-ны масштабтай цогцолбор судалгааны ажил: Агаарын геофизик-2024 төслийн хүрээнд өнөөдрийн байдлаар Агаарын геофизикийн "Tempest" цахилгаан соронзон болон нэмэлтээр нэгэн зэрэг хэмжих багажууд болох Scintrex CS-3 соронзон орны, RS радиометрийн, iCORUS хүндийн хүчний төхөөрөмжүүдээр талбайн геофизикийн цогц системээр хэмжилт, боловсруулалтын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд энэ онд гүйцэтгэх төсөв, төлөвлөгөөг ЭБМЗ-ийн хурлаар оруулж батлуулсан. Өнөөдрийн байдлаар төлөвлөгөөний дагуу геофизикийн хэмжилтийн нислэгийн ажил бүрэн хийгдэж, газрын шалгалт, дээжлэлтийн ажил, үр дүнгийн тайлан боловсруулсан.<br><br>**3. Агаарын геофизик-2025** төсөл: Монгол орны Хангайн бүсийн хэмжээнд 135,766.8 кв.км талбайд Агаарын |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | соронзон, гамма цацрагийн спектрометр (нийлбэр цацраг, уран, тори, кали) болон дагалдах судалгааг хийх Агаарын геофизик-2025 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан. Гүйцэтгэгчээр Гео сан ХХК шалгарч гэрээ байгуулан судалгааны ажлыг эхлүүлж 2025 онд 5 сувгийн хэмжилтийн нислэгийг 42700 тууш/км буюу нийт судалгааны талбайн 50%-ийг хамруулан хэмжилтийн ажлыг гүйцэтгэсэн. |
| 2 | МУХТЖҮЧ-6.3.4, ЗГҮАХ-3.3.1.2 | 1.4.1.2. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн хэтийн төлөвийн судалгаа хийх | Хэрэгжих төсөл | 2 | 1 | - | Улсын төсөв | **Өндөр технологийн түүхий эдийн хэтийн төлөвийн судалгааны ажлын ӨТТЭ-2 төсөл.** Өндөр технологийн түүхий эд II төсөл нь /ГХЭ, лити, берилли, никель, кобальт, бал чулуу/-ийн эрлийн ажил болон тэдгээрийн хэтийн төлөвийг тодорхойлон үнэлгээ өгч, тайлбар бичиг, мэдээллийн сан бүхий үр дүнгийн тайлан зохиогдсон. Өмнөх судалгааны ажлаар бүртгэгдсэн нийт 1156 илрэл, эрдэсжсэн цэгүүдээс 780 объектыг ялган авч, хээрийн судалгаанд хамруулсан. Эрлийн нарийвчилсан 8 талбайн хэмжээнд хэтийн төлөвийг тодорхойлсон: ГХЭ-10 илрэл, 1 эрдэсжсэн цэг, (Li-Be)- 10 илрэл, Ni (Co)- 2 илрэл, Ni (Cr)- 2 илрэл, Ni (Sb)- 2 илрэл, Ni-1 илрэл, бал чулууны 3 илрэл. Үүнээс баялаг тооцсон нь: ГХЭ-ийн нэг илрэлд P зэргээр 6,750 тн TR; гурван илрэлд C |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зэргээр 46.26 тн болон арван илрэлд P зэргээр 4517.89 тн TR2O3; хоёр илрэлд ГХЭ-ийн нийлмэл ислийн металл C зэргээр 36.14 тн болон P зэргээр 278.48 тн; Ni-Co-ийн нэг илрэлд P зэргээр 52,684.8 тн Ni, 940.8 тн Co, 10,348.8 тн Cr, 3,246,566.4 тн Mg, бал чулууны хоёр илрэлд P зэргээр 210,012.3 тн баялаг тооцсон үр дүнгийн тайлан зохигдож, ЭБМЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ний өдрийн хурлаар орж хамгаалагдсан. |

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

2025 оны 12 дугаар сарын 17